



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 02 дугаар сарын 13
№06 (1302)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

74.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	307
75.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	319
76.	Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	327
77.	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	328
78.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	336
79.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	340
80.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	342

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

81.	Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай	Дугаар 03	344
-----	-------------------------------------------	-----------	-----



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.17-4.1.21 дэх заалт:

“4.1.17. “олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ” гэж Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3.1.1-д заасныг;

4.1.18. “хамгаалалттай аж ахуй” гэж олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс, бүс, нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор тандалт, хяналт, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ, биохамгааллын нийтлэг зааврыг хэрэгжүүлэхээр бусад мал, амьтнаас тусгаарлан маллаж байгаа эрүүл мал, амьтан бүхий байгууламжийг;

4.1.19. “яаралтай дархлаажуулалт” гэж өвчин дэгдэх, эсхүл гаднаас нэвтрэх эрсдэл нэмэгдэх, эсхүл дахин сэргэх үеийн яаралтай хариу арга хэмжээнд хэрэглэх вакцинжуулалтыг;

4.1.20. “биохамгаалал” гэж мал, амьтны сүрэгт, эсхүл сүргээс гадагш болон сүргийн дотор өвчин, халдвар нэвтрэн орох, өвчний голомт үүсэх, тархан дэлгэрэх эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэх арга хэмжээний цогц шийдлийг;

4.1.21. “тандалт” гэж мал, амьтны эрүүл мэндтэй холбоотой тоон мэдээлэл, баримтыг төлөвлөгөөний дагуу цуглуулан нэгтгэж дүн шинжилгээ хийх, үр дүнг тухай бүрд мэдээлэх, шаардлагатай арга хэмжээг авах нөхцөл, боломжийг бүрдүүлэх цогц үйл ажиллагааг.”

2/14 дүгээр зүйлийн 14.9-14.11 дэх хэсэг:

“14.9. Энэ хуулийн 11.1.1-д заасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

14.10.Хамгаалалттай аж ахуй энэ хуулийн 14.9-д заасан нийтлэг зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх биохамгааллын зааврыг баталж мөрдүүлнэ.

14.11.Энэ хуулийн 14.2, 14.9, 14.10-т заасан журам, биохамгааллын зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.”

3/15 дугаар зүйлийн 15.5.3 дахь заалт:

“15.5.3.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.2-т заасны дагуу байгуулсан мэргэжлийн ангийг удирдлага, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тайлагнах.”

4/34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг:

“34.5.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.”

2 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “нутаг,” гэсний дараа “хамгаалалттай аж ахуй,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “тээвэрлэхдээ” гэсний дараа “мал, амьтны тавлаг байдлыг хангаж,” гэж, мөн зүйлийн 7.4.2 дахь заалтын “улсын байцаагчаас” гэсний өмнөх, 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “улсын байцаагч,” гэсний өмнөх, 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтын “мал эмнэлгийн” гэсний дараа “хяналтын” гэж, 7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсгийн “Нийслэлийн” гэсний өмнө “Аймаг,” гэж, мөн зүйлийн 7.16 дахь хэсгийн “зардлыг” гэсний дараа “аймаг,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэг:

“15.13.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажаагүй мэдээллийг тараахыг хориглоно.”

2/31 дүгээр зүйл:

“31 дүгээр зүйл. Мал эмнэлгийн хяналт

31.1. Мал эмнэлгийн хяналтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гаалийн байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн хяналтын цэгийн эрх бүхий мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

31.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэх бүтэцтэй байх бөгөөд улсын ахлах байцаагч, байцаагчтай байна.

31.3. Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч малын эмч мэргэжилтэй, бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

31.4. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мал эмнэлгийн хяналтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.4.1. Засгийн газрын эрх олгосноор гадаад улс, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах;

31.4.2. салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах.

31.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал эмнэлгийн хяналтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.5.1. Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, хяналт шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах;

31.5.2. Монгол Улсад импортлох мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг батлах;

31.5.3. олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох;

31.5.4. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын



шийдвэр, мал эмнэлгийн үйлчилгээ, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, стандарт, техникийн зохицуулалт, технологийн хэрэгжилтийг хангуулах;

31.5.5.импортлох мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл, тэжээлийн нэмэлтэд эрсдэлийн үнэлгээ хийх;

31.5.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

31.6.Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, 10.12-т заасан нийтлэг эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй байна:

31.6.1.мал, амьтан, тэдгээрийн хашаа, байр, ус, бэлчээр, өвс, тэжээлд болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих;

31.6.2.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглох, шаардлагатай тохиолдолд устгах;

31.6.3.мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй байранд эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, эм, биобэлдмэл хадгалах, худалдах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах, хадгалахыг таслан зогсоох талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

31.6.4.мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

31.6.5.мал, амьтны эм, биобэлдмэл, өвчин үүсгэгч болон бүтээгдэхүүний омог, эмийн түүхий эдийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдах, хэрэглэх, эмийн жор бичих, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл олон улсын хэрэглээнээс хасагдсан тэжээлийн нэмэлтийг зах зээлээс эгүүлэн татах явцад хяналт тавих, дүгнэлт гаргах;

31.6.6.Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сангийн хөтлөлтөд хяналт тавих;



31.6.7.мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах;

31.6.8.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт импортлох энгийн зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл, дүгнэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

31.6.9.малын эмчийн мэргэжлийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл, дүгнэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

31.6.10.мал эмнэлгийн үйл ажиллагаанд мөрдөх стандарт, техникийн зохицуулалт, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих;

31.6.11.мал эмнэлгийн үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэлд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх.

31.7.Мал эмнэлгийн хяналттай холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.

31.8.Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

31.8.1.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа, боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр, хаяг, байршил, түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалтын байдал /хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, хөргөсөн, шинэ гэх мэт/, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл агуулсан хүсэлт;

31.8.2.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт;

31.8.3.худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг.”

3/34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт:

“34.2.4.харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, төрийн өмчийн мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.”

4/34 дүгээр зүйлийн 34.3.3 дахь заалт:

“34.3.3.харьяалах нутаг дэвсгэрийн мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, төрийн өмчийн мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал.”

4 дүгээр зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “нутгийн” гэснийг “нутаг, хамгаалалттай аж ахуйн” гэж, 7 дугаар зүйлийн 7.6.3 дахь заалтын, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “нутагт” гэснийг “нутаг, хамгаалалттай аж ахуйд” гэж, 7 дугаар зүйлийн 7.7.2, 7.7.4, 7.7.5, 7.7.7 дахь заалтын, 27 дугаар зүйлийн 27.7, 27.9 дэх хэсгийн “хяналтын цэгийн” гэснийг “мал эмнэлгийн хяналтын” гэж, 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийн “нутгаар” гэснийг “нутаг, хамгаалалттай аж ахуйгаар” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг урамшуулах” гэснийг “хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “жил бүрийн 01 дүгээр сард багтаан” гэснийг “жил бүр” гэж, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “түүхий мах, өндөг, сүүний” гэснийг “мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн” гэж, 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтын “дайчилгааг зохион байгуулсан байгууллагаас” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, 33 дугаар зүйлийн 33.1.2.4 дэх дэд заалтын, 34 дүгээр зүйлийн 34.2.2.2 дахь дэд заалтын “малын” гэснийг “мал, тэжээвэр амьтны” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн “цэгийн” гэснийг, мөн хэсгийн “цаашид “хяналтын цэгийн улсын байцаагч” гэх/” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн, 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 дахь заалтын “, эрүүлжүүлэх” гэснийг, 30 дугаар зүйлийн 30.23 дахь хэсгийн “нэгдсэн” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “болон орон нутгийн” гэснийг тус тус хассугай.

Индригдэл Фолг на Нолл

Хөгжсөн Шинжлэх Ургамал

2024 оны 6 сарын 15 - 16 - өдөр

Хөгжсөн Шинжлэх Ургамал
Хөгжсөн Шинжлэх Ургамал
Хөгжсөн Шинжлэх Ургамал

1. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

2. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

3. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

4. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

5. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

6. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

7. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

8. Хөгжсөн Шинжлэх Ургамал. Хөгжсөн Шинжлэх Ургамал.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.11. “импортын мэдэгдэл” гэж гадаад улсаас импортлох мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийсний үндсэн дээр Монгол Улсад оруулахыг зөвшөөрч олгох баримт бичгийг.”

2/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:

“5.4. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хорио цээрийн хяналт, шалгалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.4.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлохын өмнө эрсдэлийн үнэлгээ хийж, импортын мэдэгдэл олгох;

5.4.2. хуульд өөрөөр заагаагүй бол гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах;

5.4.3. шаардлагатай бол экспортлох эрх бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, хянан магадалгаа хийх;

5.4.4. энэ хуулийн 5.4.3-т заасан үзлэг, хянан магадалгаа хийх журмыг батлах.”

3/10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт:

“10.1.3.Малын генетик нөөцийн тухай хуулийн 9.7-д заасан дүгнэлтийг гаргуулсан байх.”

4/11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт:

“11.1.4.гадаадад гаргах малын үржүүлгийн бүтээгдэхүүний ижил хувийг генийн санд байршуулсан тухай тодорхойлолтыг Малын генетик нөөцийн тухай хуулийн 15.1-д заасан байгууллагаас авсан байх.”

5/26 дугаар зүйлийн 26.3.4 дэх заалт:

“26.3.4.импортын мал нь монгол мал, тэдгээрээс гаралтай үүлдрийн малын удмын сан, генетик тогтолцоонд эрсдэл үүсгэж болзошгүй бол.”

2 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “мал эмнэлгийн” гэсний өмнө “олон улсын” гэж, “амьтан” гэсний өмнө “мал,” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэсний өмнөх, 26.2.1 дэх заалтын “ургамлын” гэсний дараа “удмын сан,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:

“1.1.Энэ хуулийн зорилт нь олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, шаардлагыг хангуулах, аюулгүй байдлыг баталгаажуулж холбогдох гэрчилгээ олгох, хяналт, шалгалт хийх, улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

2/7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт:

“7.1.7.гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагатай хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах,



улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлэх;

3/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.Хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан ургамлын хорио цээрийн гэрчилгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.”

4/26 дугаар зүйлийн 26.4, 26.5 дахь хэсэг:

“26.4.Эрсдэлийн үнэлгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

5/27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг:

“27.1.Эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 26.4-т заасан эрх бүхий албан тушаалтан олон улсын стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

27.2.Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 26.4-т заасан эрх бүхий албан тушаалтны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөгдөх эрсдэлтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний импортыг хүлээн зөвшөөрч импортын мэдэгдэл олгоно.”

4 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.6, 8.1.8 дахь заалтын, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх хэсгийн “экспортын” гэснийг “олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, ургамлын хорио цээрийн” гэж, 25 дугаар зүйлийн гарчгийн “Импорт, экспортын гэрчилгээ” гэснийг “Импортын, олон улсын мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “дээд шатны” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх



заалтын “гаалийн” гэснийг “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 23.3 дахь хэсгийн “Гаалийн” гэснийг “Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтын “экспорт” гэснийг “олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, мөн зүйлийн 23.3.1 дэх заалтын “хүнснийхээс бусад” гэснийг “тэдгээрийн гаралтай” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “задлан шинжилгээ” гэснийг “үнэлгээ” гэж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийн “задлан шинжилгээгээр” гэснийг “үнэлгээгээр” гэж, мөн хэсгийн “аюулыг” гэснийг “эрсдэлийг” гэж, мөн зүйлийн 26.3 дахь хэсгийн “задлан шинжилгээг” гэснийг “үнэлгээг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “цаашид “улсын байцаагч” гэх/ энэ хуулийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт дурдсан баримт бичгийг /цаашид “экспортын гэрчилгээ” гэх/ хураан авч, оронд нь” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “экспорт,” гэснийг, Зургадугаар бүлэг, 26 дугаар зүйлийн гарчгийн “задлан шинжилгээ,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.8, 3.1.9, 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.9 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

д/г Кметэн Навч / 2024 он / Эрв / Дүгээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...

д/г Кметэн Навч / 2024 он / Эрв / Дүгээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...

д/г Кметэн Навч / 2024 он / Эрв / Дүгээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...

«2024.06.06-ийн өдөр»-ийн өдөр болон өдөр...
 1. Хүндэтгэсэн гэрээний үндсэн дээр...
 2. Энэхүү гэрээний зорилго нь...
 3. Энэхүү гэрээний хүчин эрх...
 4. Энэхүү гэрээний үндсэн дээр...



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.12 дахь заалт нэмсүгэй:

“7.1.12. Мал эмнэлгийн алба.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын
Дарга

Мал эмнэлгийн алба

Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба

Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба

«...»

Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба

Мал эмнэлгийн алба
Мал эмнэлгийн алба

Мал эмнэлгийн алба

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.2.3-9.2.5 дахь заалт:

“9.2.3.гадаадаас сайжруулагч мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн авах тусгай зөвшөөрөл хүсэгч нь мал аж ахуй, малын үржүүлгийн чиглэлээр гурваас доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхэлсэн талаарх туршлагын мэдээлэл, нотлох баримт;

9.2.4.гадаадаас сайжруулагч мал авах тусгай зөвшөөрөл хүсэгч нь тухайн малыг үржүүлэхээр төлөвлөсөн бүс нутгийн бүдүүвч зураг, малын тавлаг байдлыг хангасан, стандартын шаардлагад нийцсэн зориулалтын хашаа, байр, бэлчээрлүүлэх, тэжээх талбай, усан хангамжтай эсэх талаарх мэдээлэл, нотлох баримт;

9.2.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.8-д заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь дагнан болон хослон эрхлэх үйл ажиллагааны чиглэл, мэргэжлийн хүний нөөцийн талаарх мэдээлэл, мөн хэсгийн 12.7, 12.9, 12.10-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 11.3-т заасан мэргэжлийн зэрэг дэв, итгэмжлэл бүхий мал зүйчийн мэдээлэл, эсхүл мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжтэй хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хувь.”

2/9 дүгээр зүйлийн 9.14, 9.15 дахь хэсэг:

“9.14.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.7, 12.8, 12.9, 12.10-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах тусгайлсан нөхцөл, шаардлагыг хангасан байна:

9.14.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.7, 12.8, 12.9-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 16.2-т заасан мэргэжлийн байгууллагын хяналтын доор малын генетик нөөцийг тогтвортой ашиглах;

9.14.2.гадаадаас авсан сайжруулагч малыг эрх бүхий байгууллагаас тогтоосон бүс, байршилд энэ хуулийн 11.4-т заасан үржүүлгийн хөтөлбөрийн дагуу үржүүлэх;

9.14.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.7, 12.9-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадаас мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн авах тухай бүрд энэ хуулийн 9.7-д заасан дүгнэлт авах;

9.14.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.8-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гойд ашиг шимт малаас өндгөн эс, хөврөл, үр үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, мөн хэсгийн 12.10-т заасны дагуу гадаадад гаргах бүрд энэ хуулийн 15.3.2-т заасан тодорхойлолтыг авах;

9.14.5.гадаадаас авсан сайжруулагч малыг гаалийн хорио цээрийн дэглэмд байх хугацаанд үүлдрийн гарал үүсэл, удам гарваль, гадаад шинж тэмдгийн илрэлийн үзүүлэлтийн талаар гаалийн болон мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагчийн хамтарсан үзлэг хийлгэж, тодорхойлолт авах.

9.15.Гадаадаас авсан болон гадаадад гаргасан мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг гаалийн байгууллага малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүрд цахимаар илгээнэ.”

3/16 дугаар зүйлийн 16.12, 16.13 дахь хэсэг:

“16.12.Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагч доор дурдсан үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлнэ:

16.12.1.энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2, 6.6, 6.7, 6.8 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.11, 9.12 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.6, 10.8 дахь хэсэг, 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлийн 12.2, 12.3, 12.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2, 15.3, 15.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн хэрэгжилт;

16.12.2.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ, малын үржил, селекцийн стратеги, үржүүлгийн хөтөлбөр, генийн санг хамгаалах чиглэлээр мөрдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт, үндэсний стандартын шаардлагын хэрэгжилт;



16.12.3.хууль тогтоомжид заасан бусад эрх.

16.13.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч доор дурдсан үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлнэ:

16.13.1.энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2, 8.6, 8.7, 8.9 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг, 13, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг, 16.8.1, 16.9.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн хэрэгжилт;

16.13.2.малын тоо толгойн албан татварын орлогын зарцуулалтын хэрэгжилт;

16.13.3.бэлчээрийн болон суурин, хагас суурин мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэлээр мөрдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт, үндэсний стандартын шаардлагын хэрэгжилт;

16.13.4.малын тэжээл, шимт чанар, хүрэлцээ, бэлчээрийн менежмент болон усан хангамж, аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, холбогдох журмын хэрэгжилт, малын гаралтай түүхий эд бэлтгэл;

16.13.5.хууль тогтоомжид заасан бусад эрх.”

2 дугаар зүйл.Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хүсэлтийг” гэсний дараа “тусгай зөвшөөрлийн нэр төрлөөс шалтгаалан” гэж, мөн зүйлийн 9.6 дахь хэсгийн “Энэ хуулийн” гэсний дараа “9.4-т заасан тайланг хугацаанд нь ирүүлээгүй, эсхүл энэ хуулийн” гэж, мөн зүйлийн 9.9 дэх хэсгийн “гаргахад” гэсний дараа “энэ хуулийн 15.3.2-т заасан тодорхойлолтыг үндэслэн” гэж, мөн зүйлийн 9.10 дахь хэсгийн “тоог” гэсний дараа “болон энэ хуулийн 9.7-д заасан дүгнэлтийг” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “хэрэгжүүлэх” гэсний дараа “, хяналт тавих” гэж, мөн зүйлийн 16.6 дахь хэсгийн “мал зүйч” гэсний дараа “, улсын байцаагч” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Малын генетик нөөцийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт:

“9.2.1. тусгай зөвшөөрлийн хугацаанд гадаадаас авах, гаргах малын төрөл, зүйл, үүлдэр, нас, хүйс, тооны талаарх мэдээлэл;”

2/9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг:

“9.7. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.9-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадаас сайжруулагч мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн авахын өмнө тухайн малын гарваль улс, үүлдрийн удам гарваль, ашиг шимийн үзүүлэлтийн талаар урьдчилан мэдүүлж, тэдгээрийн ашиглалтаас үүдэн гарч болзошгүй генийн хувьслын эрсдэлийн нөлөөллийн талаар Ерөнхий мал зүйчийн дүгнэлтийг авна.”

3/16 дугаар зүйлийн 16.11 дэх хэсэг:

“16.11. Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны байгууллагын улсын байцаагч хэрэгжүүлнэ.”

4 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “, гадаадаас авах сайжруулагч мал болон гадаадад гаргах малын төрөл зүйл, ашиг шимийн чиглэл, үүлдрийн нэр” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



История Фольга на Холл

Исторический очерк

№ 6 и 7 в каталоге 1900 - 1901

Исторический очерк
Исторический очерк
Исторический очерк

Исторический очерк... История... История... История...

Исторический очерк... История... История...

Исторический очерк... История... История... История...

Исторический очерк... История... История... История...

Исторический очерк... История... История... История...

Исторический очерк... История... История... История...

Исторический очерк... История... История... История...

Исторический очерк... История... История... История...

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/13.4 дүгээр зүйлийн 8-12 дахь хэсэг:

“8.Мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг энгийн зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргасан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг энгийн зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг завдсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь:

10.1.тухайн үүлдэр, омгийн малыг үржүүлэхээр эрх бүхий байгууллагаас тогтоосноос өөр бүс нутагт үржүүлсэн;

10.2.малыг сонгон үржүүлэхдээ ашиг шимийн чиглэлийг дур мэдэн өөрчилсөн;

10.3.стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг, эсхүл өөр үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Гадаадаас сайжруулагч мал авах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрх бүхий байгууллагын тогтоосноос өөр бүс нутагт малыг шилжүүлэн үржүүлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Шинжлэх ухааны дэвшилтэт аргаар малын үүлдэр, омог шинээр бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон



хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/13.9 дүгээр зүйлийн 9, 10 дахь хэсэг:

“9.Малчин, амьтан маллагч нь:

9.1.өөр сум, дүүргийн нутаг дэвсгэрээс мал, амьтан шилжүүлэн авчирсан даруй үзлэг хийлгэн тухайн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлээгүй, хяналтын цэгт шалгуулахгүй өнгөрсөн, эсхүл тогтоосон замаас өөр замаар тээвэрлэсэн, тууварласан;

9.2.эрүүл мэндийн тодорхойлолт авалгүйгээр бусад сум, дүүргийн нутаг дэвсгэрт мал оторлосон;

9.3.хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс хооронд мал, амьтан тууварласан, тээвэрлэсэн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт:

10.1.орон нутгийн онцгой комиссын зөвшөөрөлгүйгээр бэлчээр, нутаг сэлгэсэн;

10.2.нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, хүн, мал, амьтны бөөгнөрөл бий болгосон;

10.3.мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан;

10.4.халдварт өвчнөөр өвчилсөн мал, амьтан байрлаж байсан хашаа, байр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг халдваргүйтгэхээс өмнө дахин ашигласан бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



2024. május 06. és 07. között tartott közgyűlés

Magyar Föld- és Hely-

tervezési terv

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /

tervezési terv /
tervezési terv /



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.64 дэх хэсэг нэмсүгэй:

“6.64.мал аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6, 8 дахь хэсэг, 10.25, 10.29 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.43 дахь хэсгийн “7” гэсний дараа “, 8, 9, 10, 11, 12” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.43 дахь хэсгийн “мал үржлийн” гэснийг “мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.44 дэх хэсгийн “10.14” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



Модорж Фольо на Нөёл

Хэвлэлийн үйлчилгээний газар

2024 оны 6 сар 15 - 16 өдөр

Хэвлэлийн үйлчилгээний газар
Төрийн мэдээлэл
Төрийн мэдээлэл үйлчилгээний газар

1. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...
2. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...

3. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...
4. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...

5. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...
6. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...

7. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...
8. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...

9. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...
10. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...

11. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...
12. Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар... Хэвлэл үйлчилгээний газар...

Хэвлэл үйлчилгээний газар
Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний газар



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөл, ургамлын хорио цээрийн гэрчилгээ, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний загварыг импортлогч улсын эрх бүхий байгууллагатай гурван сарын дотор шинэчлэн тохирох бөгөөд ийнхүү тохирсноор хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрчилгээг олгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнө тохирсон нөхцөл, экспортын гэрчилгээний загвар хэвээр үйлчилнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг хавсралтаар өөрчлөн баталсугай.

2.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian Folio_02 Yuki Norga 02 Dowlodga

ᠠᠮᠤᠨᠭᠣᠯᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠯᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ

ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠤ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠯᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠯᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ
ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠯᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ
ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠯᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ
ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠯᠢ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ
ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠠᠯ

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилт нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоож, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Зөвлөл төсвийн бодлогын чиглэлээр бие даасан, хараат бусаар мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гарган Улсын Их Хурлын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлнэ.

1.3.Зөвлөл төсөв, санхүүгийн холбогдолтой шийдвэрийн нөлөөллийг таниулах зорилгоор олон нийтийг төсвийн талаарх мэдээллээр хангаж, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллана.

1.4.Зөвлөл эрхлэх асуудлынхаа онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болох бөгөөд тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Зөвлөлийн үйл ажиллагааны зарчим

2.1.Зөвлөл үйл ажиллагаандаа ил тод, хараат бус байх, бусдын нөлөөнд үл автах, төсвийн тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хамтын удирдлагын зарчмаар асуудлыг чөлөөтэй хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

Гурав.Зөвлөлийн эрхлэх асуудал

3.1.Зөвлөл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараах чиглэлээр ажиллана:

3.1.1.Эдийн засгийн төсөөлөл, таамаглал хийх чиглэлээр:

3.1.1.а.макро эдийн засгийн тооцооллын загварт суурилан эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл, таамаглалыг боловсруулан, олон нийт, мэргэжлийн судлаачид нягтлах боломжтой хэлбэрээр нээлттэй байршуулах;

3.1.1.б.эдийн засгийн төсөөлөл, бодлогын шинжилгээний системийг нэвтрүүлэх;

3.1.1.в.эдийн засгийн болон төлбөрийн тэнцлийн төсөөлөл гаргах загвар, аргачлалыг хөгжүүлэх чиглэлд дотоод, гадаадын судлаачид, байгууллагуудтай хамтран ажиллах;

3.1.1.г.эдийн засгийн төсөөлөл гаргахад шаардлагатай дотоод сектор /хөдөлмөрийн зах зээл, бодит сектор, үл хөдлөх хөрөнгийн зах зээл/, гадаад сектор /экспорт, импортын эрэлт, гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төлбөрийн тэнцлийн бусад данс/, салбар хоорондын тэнцэлд гарч байгаа өөрчлөлтөд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тухайлсан тайлан гаргах;

3.1.1.д.Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу эдийн засгийн тооцооллын загвар ашиглан бодлогын нөлөөллийн тооцоог хувилбартайгаар гаргаж танилцуулах.

3.1.2.Төсвийн болон хөгжлийн бодлогын тогтвортой байдалд шинжилгээ хийх чиглэлээр:

3.1.2.а.төсвийн орлого, зарлагын урт хугацааны таамаглал боловсруулах;

3.1.2.б.улсын өр болон Засгийн газрын өрийн тогтвортой байдалд дүн шинжилгээ хийх;

3.1.2.в.төсөвт нөлөөлөхүйц томоохон бодлогын шийдвэрүүдийн нөлөөллийг тооцоолох;

3.1.2.г.төсвийн орлого, зарлага, өрийн тогтвортой байдлын дүн шинжилгээнд ашиглах дотооддоо боловсруулсан загвар бий болгох, тогтмол сайжруулалт хийх;

3.1.2.д.боловсруулсан загвар, холбогдох тооцооллоо судлаачид үр дүнг нь нягтлах боломжтой хэлбэрээр олон нийтэд нээлттэй байршуулах;

3.1.2.е.төсвийн зарлагын төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

3.1.2.ё.төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох, “өр-хөрөнгө оруулалт” гэсэн системт хандлагыг шинжлэх, дүгнэх;



3.1.2.ж.урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, төсөвлөлтийн харилцан уялдаа, үр нөлөөний шинжилгээ хийх.

3.1.3.Төсөвт учрах эрсдэлийн шинжилгээ хийх чиглэлээр:

3.1.3.а.эдийн засаг болон төсөвт учрах гол эрсдэлүүдийн мэдээллийг илрүүлж, судлах;

3.1.3.б.эдийн засгийн болон төсвийн урт хугацааны таамаглалд тооцоолсноос бусад эрсдэлийг илрүүлэх, эрэмбэлэх;

3.1.3.в.тооцоололд ороогүй эрсдэлийн эдийн засаг болон төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох;

3.1.3.г.төсвийн орлогын төсөөллийн эрсдэлийг хувилбартайгаар тооцож, холбогдох шинжилгээ, судалгааг хийх;

3.1.3.д.гол эрсдэлүүдийн ялгаатай хувилбар дээр төсвийн орлогын өөрчлөлтийн төсөөлөл гаргах;

3.1.3.е.эрсдэлийг тодорхойлох, тоон утгаар илэрхийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.1.3.ё.төсвийн орлого, зарлагын бүрдлүүдийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийн судалгааг олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран хийх.

3.2.Зөвлөл дараах тайланг сар, улирал бүрээр гарган хуралдаанаараа хэлэлцэн, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, олон нийтэд мэдээлэх ба хагас жил тутам олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулна:

3.2.1.эдийн засгийн таамаглалын тайлан;

3.2.2.төсвийн эрсдэлийн болон төсвийн тогтвортой байдлын тайлан;

3.2.3.бодлогын нөлөөллийн шинжилгээний тайлан.

3.3.Зөвлөл энэ дүрмийн 3.1, 3.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааг Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, эдийн засаг, хөгжлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад төрийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас гаргуулан авч ашиглана.

Дөрөв.Зөвлөлийн хуралдаан

4.1.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

4.2.Зөвлөлийн нийт гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

4.3.Зөвлөлийн хуралдаанд шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүдийг оролцуулж мэдээлэл авч болно.

4.4.Зөвлөлийн хуралдааны явцыг хуралдааны тэмдэглэлд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

Тав.Зөвлөлийн шийдвэр

5.1.Зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд түүнд Зөвлөлийн дарга болон хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Шийдвэрийн талаар тусгайлсан саналтай гишүүний саналыг хуралдааны тэмдэглэлд тусгана.

5.2.Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

5.3.Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.1-д заасан хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 20 хоногийн дотор судалгаа, шинжилгээ хийж, гаргасан дүгнэлт, зөвлөмжөө Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

5.4.Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд Зөвлөлийн дарга, гишүүд холбогдох хууль болон энэ дүрэмд нийтэд мэдээлэхээр заасан Зөвлөлийн шийдвэрийг танилцуулахад биечлэн оролцоно.

5.5.Зөвлөл шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран судалгаа, шинжилгээний ажил хийж болно.

Зургаа.Зөвлөл Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороотой харилцах

6.1.Зөвлөл нь Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороог энэ дүрэмд заасан судалгаа, шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, холбогдох бусад мэдээллээр хангаж ажиллана.

6.2.Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт болон үйл ажиллагааныхаа талаар хагас жил тутамд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд тайлагнана.

6.3.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийн талаар шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас холбогдох тайлбарыг гаргуулж авна.

Долоо.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа, үйл ажиллагаа явуулах баталгаа

7.1.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

7.2.Зөвлөлийн гишүүнийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.6}-д зааснаас бусад тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг хориглоно.

7.3.Зөвлөлийн дарга, гишүүний цалин хөлс болон Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусган батлах бөгөөд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга захиран зарцуулна.

Найм.Төсвийн судалгааны нэгж

8.1.Төсвийн судалгааны нэгж нь Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж байх бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.7}-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллах ба Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэнэ.

8.2.Төсвийн судалгааны нэгж нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төрийн захиргааны албан хаагч байна.

8.3.Зөвлөлийн дарга нь Зөвлөлийн болон Төсвийн судалгааны нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

Ес.Зөвлөлийн дотоод мэдээллийн нууцыг хадгалах

9.1.Зөвлөлийн дүрэмд зааснаас бусад тохиолдолд Зөвлөлийн гишүүн болон Төсвийн судалгааны нэгжийн ажилтан Зөвлөлийн дотоод мэдээлэл гэж тогтоосон, нийтэд зориулагдаагүй мэдээг тараах, бусдад мэдээлэх, хувийн зорилгодоо ашиглахыг хориглоно.

---ооо---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.25

Индекс: 200003